



MONGOLIAN TRANS LINE

**“ЗҮҮНБАЯН-ХАНГИ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ”-ИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БАЙРШИЛ: ДОРНОГОВЬ АЙМАГ, МАНДАХ, УЛААНБАДРАХ, ХАТАНБУЛАГ, ХӨВСГӨЛ
СУМ

РЕГИСТРИЙН ДУГААР: 5507227

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2
2.1 Төслийн талбайн байршил.....	2
2.2 Нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөв.....	3
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
3.1 Агаарын чанар.....	7
3.2 Физик бохирдол.....	9
3.3 Гадаргын болон газрын доорх ус.....	10
3.4 Хөрсөн бүрхэвч.....	11
3.5 Ургамлан нөмрөг.....	11
3.6 Амьтны аймаг.....	12
3.7 Тусгай хамгаалалттай газар нутаг.....	12
3.8 Түүх, соёлын биет өв.....	12
3.9 Нийгэм, эдийн засаг.....	13
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	13
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	13
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..	15
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	27
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	30

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уг төсөл нь Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн төмөр замын 113 дахь километрээс эхлэн Дорноговь аймгийн Ханги боомт хүртэл 226.9 км үргэлжилж, улмаар БНХАУ-ын хилийн Мандал боомттой холбогдох төмөр замын төсөл юм.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам баригдсанаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн төв болох Бугат хот руу нийлүүлэх Монгол Улсын экспортын төмрийн хүдэр, нүүрсний өрсөлдөх чадвар, бараа эргэлт нэмэгдэн, тээвэрлэлтийн өртөг буурснаар Монгол Улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулах шинэ төмөр замын чиглэл болно.

- Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам нь
- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого
- “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 104 дүгээр тогтоолоор Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ байгуулах эрхийг “Монголиантранс лайн” ХХК, “Монголиан транс ложистик” ХХК-ны нэгдэлд олгогдож “Төрийн худалдан авах ажиллагааны газар”-тай 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр концессын гэрээг байгуулан төслийг хэрэгжүүлсэн.

Тус төслийн хүрээнд 242 цэгт төмөр бетон хоолой, 4 цэгт төмөр бетон гүүр төлөвлөн байгуулсан. Ус зайлуулах хоолой, гүүрнүүдийг замын дагуух хуурай голын голдиролтой газрууд, үерийн их хэмжээний ус, гол горхи урсгах зориулалттай байгуулсан бөгөөд үүнээс 5.5х5 м хэмжээтэй 30 гүүрэн хоолойг амьтдын нүүдлийн замд буюу зэрлэг болон тэжээвэр амьтдад зориулан хийсэн.

Төмөр замын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Өгөгдөл
1	Гол замын нийт урт	226.9 км
2	Дэлгэмэл урт	352.6 км
3	Нэг голын даралт	25 тонн
4	Замын цариг	1520 мм, 1435 мм
5	Удирдах хэвгий	Ачаа талдаа 6% Хоосон талдаа 9%
6	Гүүрийн тоо	4
7	Ус өнгөрүүлэх хоолойн тоо	235 цэгт
8	Суман шилжүүлгийн төрөл	ТВ60 стандарт, 1/11, 1/9
9	Нэг км дэх дэрний тоо	Шулуунд ба 1200 м ба түүнээс их радиустай тахирт - 1667 шир/км 1200 м-ээс бага радиустай тахирт 1840 шир/км
10	Хамгийн бага радиус	Байх ёстой нөхцөлд 4000-1200 м Хүнд нөхцөлд 800 м
11	Зам төмрийн маяг	ТВ60 стандарт ТВ/Т 2344-2012
12	Чигжээсний төрөл	Бутармал чулуу
13	Бэхэлгээний төрөл	Пандрол, CZ, APC
14	Галт тэрэгний дээд хурд	100 км/цаг

Эдийн засгийн үндэслэл

Төвийн болон Өмнийн говийн уул уурхайн бүтээгдэхүүнийг БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх, улмаар олон улсын зах зээлд гаргах төмөр замын дэд бүтэц шаардлагатай байна. Энэ нь Монгол Улс экспортын ачаа тээврийг тээвэрлэх дэд бүтцийн хөгжлөөс хамаарч жил бүр олон тэрбум ам долларын орлогыг алдаж байгаа нь эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлж байна.

Олон улсад жил бүр тээвэрлэлтийн зардал болон бүс нутгийн ачаа эргэлтийн хэмжээ тогтвортой өсөн нэмэгдэж байгаа нь энэхүү төмөр замын шинэ шугамыг барих эдийн засгийн бодитой үндэслэл болж байгаа юм.

“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдэх голлох ачаа нь Тавантолгойн нүүрс болон төмрийн хүдэр байх боловч мөн тодорхой хэмжээний бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн тээвэрлэгдэх боломжтой.

Тодруулбал, 150 сая тонн орчим батлагдсан нөөцтэй Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дэх ордуудаас коксжих нүүрсийг жилд 2-4 сая тонныг, 0.3-0.5 сая тонн зэсийн баяжмалыг, мөн БНХАУ-ын Бугат хот руу ОХУ-аас транзитаар тээвэрлэгдэх боломжтой 1-6 сая тонн нефть, 1 сая тонн мод, Ханги боомтоор БНХАУ-д экспортлогдож байгаа 1.5 сая тонн ачаа, УБТЗ-ийн сүлжээгээр дамжин Бугат, Хөх хотын бүс рүү нийлүүлэгдэж байгаа 1 сая орчим тонн ачаа бараа, Бугат-Зүүнбаян чиглэлд тээвэрлэх 1-2 сая тонн барилгын материал, металл хийц, нефтийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, хүнд машин механизм зэрэг бараа бүтээгдэхүүнийг “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замаар тээвэрлэх боломжтой.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбайн байршил

“Монголиантранс лайн” ХХК-ийн “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл”-ийн трасс 248.5 км үргэлжилнэ. Тус компанийн төмөр замын трасс нь Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутгийг дайран өнгөрөх бөгөөд үүнээс Мандах сумын нутаг дэвсгэрт 18 км орчим, Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт 11 км орчим, Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт 146 км орчим, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт 51 км орчим урттай үргэлжилнэ. (Зураг 1-ээс дэлгэрэнгүй харах).



Зураг 1. Төслийн ерөнхий байршил (Тод ногоон)

2.2 Нийгэм эдийн засгийн ерөнхий төлөв

Дорноговь аймаг нь 14 сум, 65 багтай, 109.4 мянган км² газар нутагтай. Баруун өмнөд талаараа Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баруун талаараа Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан, Баруун хойд талаараа Говьсүмбэр аймгийн Шивээговь, Баянтал сум, хойд талаараа Хэнтий аймгийн Дархан, Галшар, зүүн хойд талаараа Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Баяндэлгэр сумдтай, өмнө талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-той тус тус хиллэдэг

2019 онд Дорноговь аймгийн хүн амын дундаж наслалт 2010 оноос 4.3 жилээр нэмэгдэж 71.6 болж, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 3.8 дахин нэмэгдэж 405.4 тэрбум төгрөгт хүрч, нэг хүнд ногдох дотоодын нийн бүтээгдэхүүн 2010 оноос 3.2 дахин нэмэгдэж 5.8 саяд хүрч, сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлснээр малчдын ахуй соёлын үзүүлэлт сайжирч, холбоо, мэдээллийн хэрэглээний зөрүү эрс багассан зэргийг дурдаж болох юм.

Мөн Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны байгууллагаас гаргадаг аймгуудын өрсөлдөх чадварын тайлангийн 2023 оны ерөнхий дүнгээр Дорноговь аймаг хамгийн их амжилт гаргаж 2 дугаар байранд эрэмбэлэгдэж, өрсөлдөх чадварын үзүүлэлтээ нэмэгдүүлж чадсан бөгөөд аймгийн бизнесийн үр ашиг, дэд бүтцийн үзүүлэлтүүд илүүтэй сайжирсан байна.

Аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь хөдөө аж ахуй юм. Дорноговь аймаг 2010 онд 1056.8 мянган малтай байсан бол 2019 оны эцэст 2404.2 мянган толгой малтай болж 2.3 дахин өссөнийг малын төрлөөр авч үзвэл тэмээ 54.8 хувиар, адуу 97.1 хувиар, үхэр 2.3 дахин, хонь 2.4 дахин, ямаа 2.2 дахин тус тус өссөн байна.

Аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 2000 онд 2289.6 сая төгрөг байсан бол 2005 онд 3527.1 сая, 2010 онд 2974.3 сая, 2015 онд 10509.3 сая, 2019 онд 198144.2 сая төгрөгт хүрсэн байна. Аж үйлдвэрийн салбарын 2019 оны нийт үйлдвэрлэлтийн 45.1 хувийг уул уурхай, олборлох салбар, 50.6 хувийг боловсруулах салбар, 4.3 хувийг цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбар эзэлж байна. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт 2019 онд 170.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь арван жилийн өмнөхөөс бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлын хэмжээ 6.7 дахин өссөн байна.

Ашигт малтмал: Тус аймаг ашигт малтмалаар баялаг бөгөөд одоогийн байдлаар хайлуур жонш, цеолет, гөлтгөнө, чулуун нүүрс, газрын тос, алт, зэс, никель, төмөр, марганец, хром, гянт болд, цагаан тугалганы зэрэг 38 төрлийн ашигт малтмалын 73 орд, 440 гаруй илэрцүүд тогтоогдсон байна. Мөн тус аймагт Монгол орны хэмжээнд тогтоогдсон хайлуур жоншны нийт нөөцийн 30.0 хувь бий. Байгалийн баялаг, ашигт малтмал, эрдсийн энэхүү ихээхэн нөөц нь уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэл хөгжих тааламжтай нөхцөл болж байна.

Цахилгаан эрчим хүч: Дорноговь аймгийн бүх сумд цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон бөгөөд үйл ажиллагааг БЗӨБЦТС ТӨХК-ийн Чойр, Дорноговь салбар, УБТЗ ХНН-ийн ЭХУХ 2-р анги тус тус хариуцан ажилладаг байна. Дулаан хангамж: Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ, Замын-Үүд, Сайншанд сумд болон Зүүнбаян баг нь төвлөрсөн ус, дулаан хангамжийн шугам сүлжээнд холбогдсон.

Төмөр замын салбар: Улаанбаатар-Сайншанд Замын-Үүдийг холбосон 726 км, Сайншанд-Зүүнбаян өртөө хүртэл 47 км төмөр замтай. Хоногтоо ачаа тээврийн 18-22 хос галт тэрэг, суудлын 6 буюу нийт 980 орчим зорчигчийн галт тэргийг явуулж байна. Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.

Авто замын салбар: Дорноговь аймгийн авто замын сүлжээний нийт урт 3000 гаруй км авто замтай бөгөөд үүнээс Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн улсын чанартай 434.1 км хатуу хучилттай авто зам эзэлдэг.

Төсөл хэрэгжих сумдын мэдээлэл:

Мандах сум нь Сайншанд сумаас 170 км, Улаанбаатар хотоос 454 км зайд оршдог. 12.7 мянган км² нутаг дэвсгэртэй, 5 багтай, 1553 хүн амтай, 189007 толгой малтай. 2017 оны 6 дугаар сард төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн. Тус суманд 250 хүүхдийн ЕБ-ын сургууль, 84 ортой дотуур байр, 10 ортой хүн эмнэлэг, 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, 200 суудалтай соёлын төв ажилладаг.

Улаанбадрах сум нь Сайншанд сумаас 138 км зайд оршдог, 11.4 мянган км² нутаг дэвсгэртэй, 4 багтай, 1,476 хүн амтай, 157,347 толгой малтай. Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож, үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн холбогдсон. Тус суманд 240 хүүхдийн ЕБ-ын сургууль, 60 ортой дотуур байр, 9 ортой хүн эмнэлэг, 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, 200 суудалтай соёлын төв ажилладаг.

Хөвсгөл сум нь Сайншанд сумаас 170 км зайд оршдог, 8.4 мянган км² нутаг дэвсгэртэй, 4 багтай, 1,561 хүн амтай, 159,144 толгой малтай. Төвийн эрчим хүч болон үүрэн телефоны сүлжээнд холбогдсон. Тус суманд 400 суудалтай ЕБ-ын сургууль, 60 ортой дотуур байр, 8 ортой хүн эмнэлэг, 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, 240 суудалтай соёлын төв ажилладаг.

Хатанбулаг сум нь Сайншанд сумаас 240 км зайд оршдог, 18.7 мянган км² нутаг дэвсгэртэй, 6 багтай. 2,850 хүн амтай, 260,184 толгой малтай. 2017 оны 6 дугаар сард төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн. Тус суманд 400 суудалтай ЕБ-ын сургууль, 60 ортой дотуур байр, 12 ортой хүн эмнэлэг, 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг, 200 суудалтай соёлын төв ажилладаг.

2.3. Төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал

"Зүүнбаян - Ханги чиглэлийн 226.9 км урттай төмөр зам нь Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг гэсэн 4-н сумын нутаг дэвсгэрт хамаарна.

Физик газарзүйн мужлалаар: Говийн их мужийн Дорнод говийн дэд мужийн Сулинхээр-Замын-Үүдийн талархаг газар болон Дорнод говийн хотгорын тойрогт, Байгалийн бүс, бүслүүрээр Цөлийн болон цөлөрхөг хээрийн бүсэд, Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг их мужид, Гадаргын усны Ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай сав, Гидрогеологийн мужаар (Газар доорх усны тэжээлийн горим) Улирлын хомс тэжээлтэй муж, Дорноговийн дэд мужид, Монгол орны ус сав газраар Галба-Өөш-Долоодын говийн сав газарт, Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн заримдаг цайвар бор хөрсний дэд бүсийн Дорноговийн тойрогт, Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт, Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол-Түвдийн их муж, Монголын ойт хээрийн дэд муж, Дорнод говийн тойрогт тус тус хамрагдаж байна.

Уур амьсгал: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь эх газрын эрс тэс уур амьсгал тэр дундаа хуурайвтар дулаан бичил уур амьсгал зонхилно. Монгол орны хэрэглээний уур амьсгалын хэв шинжийн ангиллаар “Хахир хүйтэн өвөлтэй, халуун хуурайдуу зунтай” YI- A дэд ангид багтана.

Энэ ангийн гол онцлог гэвэл 7, 8-р сарын хур тунадасны горимтой, өвөл нь богино бусад нутгаас дулаан, хавар нь эрт дулаардаг, хуурай салхи ихтэй, хавраас намар нь илүү чийглэгдүү, зун нь нарлаг халуун болдог. Дулааны хуримтлал, үргэлжлэл болон эрчим нөөцөөрөө бүс нутагтаа хамгийн их учир тэнд хайгуулын болон ашиглалтын ажил хийх хугацаа бусад нутгаас 30-50 хоногоор урт байдаг онцлогтой.

Олон жилийн дундаж агаарын температур мэдээллээс үзэхэд Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт жилийн дундаж агаарын температур 1°C- ээс 3°C-ийн хооронд хэлбэлздэг бол Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдын нутаг дэвсгэрийн жилийн дундаж агаарын температур нь 5°C - 7°C-ийн хооронд байна. жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ Мандах сумын урд тал Хөвсгөл, Хатанбулаг сумын хойд талаар 50-100 мм, Хөвсгөл, Хатанбулаг сумаас урагшлах тусам хур тунадасны хэмжээ нэмэгдэж байна.

Гадаргын ус: Төв Азийн гадагш урсацгүй ай савд орших гол, горхиуд Монгол орны нийт урсцын 40 орчим хувийг бүрдүүлдэг боловч Галба-Өөш, Долоодын говийн сав газарт гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи байхгүйгээс ус зүйн хувьд төдийлөн сайн судлагдаагүй, хур борооны уснаас хамааралтай тогтмол биш ундаргатай цөөнгүй тооны булаг, шанд, нуур, цөөрөм л байдаг. Гадаргын урсац 5 мм, газар нутгийн нийт чийгшил 50-100 мм, голын сүлжээний нягтшил 0.01-0.05 км/км², гол мөрний нийлбэр урсац 0.5-1 л/с-км², усны гадаргаас уурших ууршилт 5-9 дугаар сард 900-1100 мм байна.

Газрын доорх ус: Монгол орны гидрогеологийн дүүрэгчлэлийн зургаас харахад гидрогеологийн системийн өмнөд хэсэгт төмөр замын трассын 0-84 км нь Дорноговийн, 85-163 км Галбын говийн, 164- 228 км Тэнгэр тойрмын газрын доорх усны ай савуудад мөн

монгол орны усны сав газрын ангиллаар Галба-Өөш-Долоодын говийн сав газарт орж байна.

Төмөр замын трасс орчмын газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь 0-27 км орчимд 10-20, 20-50 мм/жил/км², 57-75, 81-83 км орчимд 5-10 мм/жил/км², үлдсэн км-үүдэд 5 < мм/жил/км² байна. Нөхөн сэргээгдэх нийт нөөц нь 1118 км² талбайд 1.59 сая м³/жил, газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц 3.11 сая м³/жил байна.

Хөрсөн бүрхэвч: Судалгааны талбай нь Монгол орны хөрс - газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн заримдаг цайвар бор хөрсний дэд бүсийн Дорноговийн тойрогт хамаарч байна. Хөрсөн бүрхэвч нь чулуурхаг боловч шавранцар, элсэнцэр фракц нэлээн оролцоно. Хамгийн түгээмэл хэв шинжийн хөрс бол цөлийн болон цөлөрхөг хээрийн хөрс юм. Энэ хөрс цав толгод, ухаа гүвээг бүрхэнэ. Харин хотос хонхруудаар хужирлаг хөрс, шалархуу хөрс, сайрын хөрс тархана. Төмөр замын трассын дагууд уулын цөлөрхөг хээрийн бор хөрс, нугын хужир /чийгт хэлбэрийн хужир/ хөрс, сулавтар бэхэжсэн элсэн хөрс, цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, шал, шалархуу хөрс тус тус зонхилон тархана.

Ургамлан нөмрөг: Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж буй болсон, биеэ даасан үүсэлтэй, зөвхөн энэ бүсдээ ургадаг зонхилгогч ургамлуудтай байдгаараа онцлогтой. Монголын цөлөрхөг хээрт амьдралын хэлбэрийн хувьд хуурайсаг сөөгөнцөрүүд нэлээд оролцож, дэгнүүлт жижиг үетэн зонхилдгоороо онцлог юм. Энэ бүсэд өдлөг хялгана-боролзойт хээр, өдлөг хялгана-таанат цөл, өдлөг хялгана- таана-бударганат, өдлөг хялгана-бударганат, харгана-өдлөг хялганат, тэсэг-өдлөг хялганат, хотир-өдлөг хялгана, бор бударганат, бор бударгана-хойрог, Ахар навчит баглуурт болон сөөгт цөлөрхөг хээр их тохиолдоно.

Сүүлийн жилүүдийн мэдээнээс үзэхэд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн ургамалжилт бага зэрэг өсөх хандлагатай байна. Ургамлын нормчилсон индексийн утга 2016 онд хамгийн өндөр, 2014, 2015, 2017 онуудад утга бага дүнтэй байна.

Амьтны аймаг: Төсөл хэрэгжих газар нь бүхэлдээ Дорнод говийн тойрогт орох бөгөөд энэ бүс нутагт хөхтөн амьтдаас говь, цөлийн бүсийн түлхүүр зүйл болох хулан, цагаан зээр, хар сүүлт зээр, сибирь алагдаага, говийн ногтруу, шар чичүүл зэрэг амьтад түгээмэл тархсанаас гадна саарал чоно, шар үнэг, хярс үнэг, эрээн хүрэн, хотны үен, бор туулай, бозлог зурам, монгол огдой, үлийн цагаан оготно, морин чичүүл зэрэг амьтад, шувуудаас нөмрөг тас, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, сохор элээ, харцага, шилийн сар, хээрийн бүргэд, цармын бүргэд, өвөгт тогоруу, нарийн хиазат, зэвэн хиазат, дорнын хиазат, улаан хөлт хөхчүү, сүүл цагаан хөхчүү, хөх дэглий, говийн ногтруу, хадны тагтаа, хөхвөр тагтаа, шар шувуу, хотны бүгээхэй, хурын ураацай, өвөөлж, хулан жороо, хар хэрээ, хон хэрээ, асрын алтан хараацай, хондлой цагаан ураацай, дэрсний жиргэмэл, шоорон алаг болжмор, бүжимч чогчиг, хээрийн бор шувуу, оронгийн бор шувуу, хадны бор шувуу, хөх цэгцгий, шар цэгцгий зэрэг шувууд, хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл, суман могой, монгол бах зэрэг мөлхөгч, хоёр нутагтан тохиолдоно.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хавсралтад бүртгэгдсэн саарал чоно (II хавсралт), аргаль (II хавсралт), хулан (I хавсралт) зэрэг амьтдын тархац нутагтай төслийн талбай давхцаж байна.

Төсөл хэрэгжих талбайн өмнөд хэсэг нь Улсын хилийн орчны бүсэд ордог бөгөөд малын бэлчээрт төдийлөн өртдөггүй тул хулан, хар сүүлт зэрэг амьтдын хувьд амьдрах таатай орчин болдог.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Дорноговь аймгийн хэмжээнд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 10, Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 212, Мандах сумын хувьд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 3, Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 17, Хатанбулаг сумын хувьд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 2, Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 14, Хөвсгөл сумын хувьд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 1, Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан 24 газар нутаг бүртгэлтэй байна.

Төсөл хэрэгжих талбай нь Улсын тусгай хамгаалалтад авсан Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсгийн орчны бүстэй, Орон нутгийн тусгай хамгаалалттай Толийн булаг, Өөшийн говь, Бор нуруу, шар заагийн хоолой гэсэн 3 газартай давхцалтай байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлгийн зорилго нь Дорноговь аймгийн Мандах, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сумын нутагт хэрэгжих “Монголиантранс лайн” ХХК-ийн “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл” байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино.

3.1. Агаарын чанар

Зам барилгын ажлын үеийн агаарын бохирдол

Төсөл хэрэгжих орчны хэт хуурай уур амьсгал, хүчтэй салхи, говь цөлийн хөрсний нунтаг хөнгөн үе давхарга нь тоосжилтыг үүсгэх нөхцөлтэй. Зам барилгын ажил хийхэд агаарт түр хугацаанд тоос шороо босож, бохирдол үүсэхээр байна.

Тухайлбал :

- Хөрс хуулалтын үед хуурай хөрснөөс гарах тоос;
- Чулуу бутлалт, хайрга, дайрга, шорооны карьераас олборлолтын үед;
- Элэгдэж талхлагдсан хөрс, материал тээвэрлэлтийн түр зам харгуйгаас босох тоос шороо болон,
- Зам барилгын үед ажиллах машин механизм, техник хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас ялгарах хорт хий, утаа тортог

Тээврийн хэрэгсэл эзэмшигч нь хууль -д зааснаар Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хий (CO₂)-н төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр тооцож тогтсон хугацаанд төлөх ёстой.

Тоосжилтыг багасгах менежмент, хянах стратегиуд нь хүний эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэнэ. Манай улсад мөрдөж байгаа стандарт нь тоос шорооны бохирдлын найрлага нь хүний эрүүл мэндэд нөлөөлөхгүй байх хэмжээнд үндэслэгдсэн (PM_{10} , $PM_{2.5}$).

Автомашинаас ялгаран гарах утааны найрлагад хүний амьсгалын замын архаг өвчин үүсгэх элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх, судас, мэдрэл, сэтгэхүйн системийн эрхтний үйл ажиллагааг алдагдуулах, амьсгал боогдуулах, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй 200 гаруй төрлийн хорт бодис агуулагддаг бөгөөд эдгээр нь хүний амьсгалын түвшинд шууд тархдаг сөрөг нөлөөтэй. Төслийн бүтээн байгуулалтын явцад автомашины эрчимжил нэмэгдэж улмаар агаар бохирдуулагч хорт бодис ихсэх хандлага ажиглагдана. Харин бүтээн байгуулалтын ажил дуусаж төмөр зам бүрэн ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлснээр автомашины эрчимжил эрс цөөрч агаар бохирдуулагч хорт бодисын агууламж багасна.

Тоосны бохирдолтын нэг удаагийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ $0.5\text{г}/\text{м}^3$ -аас ихгүй байдаг бол барилгын ажлаас ялгарах тоосны хэмжээ төслийн талбайд ажлын явцаас үүсэх тоосжилт зөвшөөрөгдөх хэмжээнээс нэмэгдэнэ.

Тоос, тоосжилтын хэмжээнд салхины хурд маш чухал үүрэгтэй. Төсөл хэрэгжиж буй талбай нь говь цөлийн бүсэд орших учир хүчтэй салхи гарах өдрийн тоо их, мөн уул зүй муу хөгжсөн, хавар эрт дулаарч, намар орой хүйтэрдгээс тоосжилт дэгдэх нь элбэг тохиолдох учир тоосжилтоос урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Төмөр зам байгуулах үйл ажиллагааны явцад төслийн талбай руу шороон материал, элс, дайрга, цемент болон бусад бэлэн бэлдэц, орц бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, сэлбэг материалыг тээвэрлэж буй шороон зам, элс, дайргын нунтаг тоосонцор, тэнд ажиллаж байгаа машин, техникийн түлшний дутуу шаталтаас ялгарах хорт бодис (угаарын хий, нүүрстөрөгчийн давхар исэл, хар тугалга, бензоприн)-ууд нь тухайн орчны агаарыг бохирдуулна. Эдгээр бохирдол нь агаараас гадна ойр орчмын хөрс, ургамал, амьтан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бульдозер, экскаватор, ачигч зэрэг хүнд даацын тээврийн хэрэгсэл механизмууд ажиллаж түлш шатаан, хорт хий ялгаруулна.

Барилгын материал (цемент, бетон), машин техникийн тос тосолгооны материалын сав, шатах тослох материалаар машин техникийг цэнэглэх үед ууршилт үүсэх, асгарах, нүүрсний хаягдал, ажилчдын тосгоны хатуу, хий, шингэн хаягдлууд агаар орчныг тодорхой хугацаанд бохирдуулж болзошгүй.

Зам ашиглалтын үеийн агаарын бохирдол

Ашиглалтад орсон төмөр замаар нүүрс ачсан галт тэрэг явж мөн тооны галт тэрэг буцаж ирэх галт тэрэгний хөдөлгөөн хийгдэнэ. Ирж буцах аялал хийж буй эдгээр галт тэрэгний зүтгүүрээс бохирдуулагч бодис (хий)-ууд агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Төслийн агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Шороо, элс, хайрга, чулуу олборлолт. Төмөр замын далангийн үндсэн түүхий эд болох элс, хайрга чулууг төлөвлөсөн төмөр замын трассын ойр орчмын ордуудаас олборлоно. Ордын ухаашаас түүхий эд олборлох үйл ажиллагаанаас орчны агаарт тоос, тоосонцор хаягдана.

Технологийн түр зам. Төслийн гол агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь тээврийн замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас ялгарах тоос, тоосонцор юм. Төсөл хэрэгжиж буй бүсэд далан барихад шаардлагатай түүхий эдийг ойр орчмын ухаашаас тээвэрлэх тээвэр болон бусад төмөр зам барихад шаардлагатай материал тээвэрлэлт шороон замаар явагдана. Тээвэрлэлт нь овоолго тээврийн хүнд даацын тээвэр болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрдэнэ.

Төмөр замын байгуулах үйл ажиллагаа. Төмөр замын далангийн түүхий эдийг даланд буулгах, далан болон төмөр зам барихад ашиглагдах техник хэрэгслийн үйл ажиллагаанаас орчны агаарт нөлөөлнө.

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг. Түлшний найрлагад агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик, нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.

3.2. Физик бохирдол

Дуу шуугианы нөлөөлөл:

Үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу шуугиан: Үйл ажиллагаа эхлэхэд дуу шуугиан үүсгэх гол хучин зүйл нь хүнд машин механизмаас гарах дуу шуугиан үүснэ. Төслийн талбай нь ихэнхдээ байгалийн салхитай байдаг болон орон нутгийн цаг уурын станцын мэдээнээс үзэхэд жилийн ихэнх хугацаанд баруун, баруун өмнө болон баруун хойноосоо салхины дундаж хурд нь 5.6-6.0 м/с салхитай бөгөөд салхины чиглэлийн давтагдал нь баруун, баруун хойноосоо 22.6%-22.7% байгаа нь дуу шуугианы түвшин өндөр гарахад нөлөөлж болзошгүй.

Зам барилгын ажлын дуу чимээ яах ч аргагүй үүсэх ба өнөөгийн дуу шуугианы түвшин дээр нэмэгдсэнээр нөлөөлөл ихэснэ. Нөлөөллийг багасгах буюу бууруулах маш төвөгтэй.

Төмөр замыг ашиглах буюу түүгээр тээвэрлэлт хийх явцад дуу чимээ их гарна. Ачилт буулгалтын байгууламжийн ойр хүн амын төвлөрөл үүсвэл тэдгээрт ашиглалтын үед дуу чимээний нөлөөлөл үүснэ.

Ажиллах орчны дуу шуугиан: Дуу шуугианы түвшин 85 дБА-ээс хэтэрсэн тохиолдолд хүний сонсголын эрхтэнд сөргөөр нөлөөлөх ба 8 цагийн турш хөдөлмөр эрхлэгсдийн сонсголын эрхтэн нь гэмтэхээс сэргийлсэн байршил зэргийг анхаарах хэрэгтэй.

Улмаар хөдөлмөр эрхлэгсдийн ажлын эрч хүчээ төвлөрүүлэх шаардлагатай ажлын талбайд нэмэлт дуу шуугианыг 85 дБА-ээс хэтрүүлэхгүй байхаар төлөвлөх шаардлагатай.

Иймээс дээрх зорилт бүхий төлөвлөгөө нь толгойн өвчинтэй хамааралтай ажлын эрч хүч сулрах, удаан хугацааны туршид дуу шуугиантай орчинд ажилласнаар сэтгэлзүйн хувьд дарамт учруулах зэргээс сэргийлэх юм.

Хог хаягдлын нөлөөлөл:

Шингэн болон хатуу хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсний бүтэц, бүрэлдэхүүн, үржил шимд нөлөө үзүүлнэ.

Хог хаягдлыг тодорхой хугацаанд зайлуулаагүйн улмаас их хог хаягдал үүссэн тохиолдолд элдэв үнэр, хагас задарсан ба задраагүй органик үлдэгдлийн хэмжээ ихсэж мэрэгчид, хортон шавж, нян бактери өсөж үржиж ан амьтан, хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлнэ.

Хог хаягдал хаях цэгийг байгуулахдаа болзошгүй нөлөөллийг тооцоогүйн улмаас салхи шуурганд хөнгөн хог хаягдал хийсэх, хур борооны усаар хог хаягдал урсаж хөрс, усыг бохирдуулах болон халдварт өвчин үүсгэж болзошгүй.

Ажилчдын байрнаас гарсан бүх төрлийн хог хаягдлыг орон нутгийн захиргааны шийдвэрийн дагуу дахин боловсруулах эсвэл зааврын дагуу хог хаях цэгт хүргэх шаардлагатай.

3.3. Гадаргын болон газрын доорх ус

Төмөр замын бүтээн байгуулалтын үед шууд замаар гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэхгүй.

Төмөр зам дагуух хуурай сайруудын голдирлыг хааж төмөр зам тавьснаар хаврын шар усны, зун хур борооны үер нь хэсэг хугацааны турш хүчтэй урсана. Энд үерийн усны голдирол өөрчлөгдөх ба хүчтэй урсах үерийн ус төмөр замын даланг нураах магадлалтай;

Төмөр замын үер усны гаргалгаа хоолой, гарцуудын тулгууруудын доод хэсэгт салхи болон усаар элс туугдан ирж хуримтлагдана. Үүнийг тухай бүр цэвэрлэх боломжгүй нөхцөлд энэ хуримтлал ихэссээр үерийн ус өнгөрөөх төмөр бетон хоолой, нүхэн гарцыг бөглөж зохиомол үер үүсгэж, улмаар зам, гүүр хоолой эвдэрнэ;

Говь хээрийн хөрсний онцлог шинж чанар, сайр гуу жалга нь усанд амархан идэгддэг, урсамтгай, усны урсац тогтворгүй байнгын өөрчлөлтөд орж байдаг зэрэг онцлог байдлыг харгалзан үзэлгүйгээр гүүр хоолой барих, хийцийн материал сонголтод алдаа гаргаснаас тэдгээрийн тулгуур суурь амархан эвдрэх нөхцөлийг бүрдүүлж болно;

Ус чийгтэй газарт ул шороо байгуулах үеийн дэвсгэрт шаардлага хангахгүй элс хайрга ашиглах, дэвсгийн нарийсалт, хамгаалах хашлага бариагүй зэрэг технологийн алдаа нь хожим ашиглалтын үед ул шороо ёроол хэсгээрээ нурах, ус шүүрэх, эвдрэх нөхцөлтэй;

Төмөр замын дагуу үерийн усыг гүүр хоолой руу өнгөрөөх хамгаалалтын суваг шуудуу бариагүй, замын дагууд ул шорооны ёроолоор хөрсийг тэгшлэх хамгаалалтын арга хэмжээ аваагүйгээс ул шорооны дагууд хажуу ойроор хөрс угаагдах, тогтоол нуур үүсэх, цаашид ул шороо эвдрэх нөхцөл бүрдэж болно;

Ул шорооны хажуу ойр ус хуримтлагдсанаас газрын доорх усны түвшин нэмэгдэж намагшина. Үүнээс үүдэн хөрсний хөлдөлт гэсэлтийн нөлөөгөөр зам барилга гажиж ашиглалтын хугацаа богиносно;

Зам барилгын ажил, далан байгуулах, орчны тоосжилтыг бууруулах зэрэгт ус ашигласнаар тухайн орчмын бага гүнд орших усны түвшин тодорхой хугацаанд доошилж хэмжээ нөөц багасах сөрөг нөлөөтэй.

Ахуйн хатуу, шингэн хаягдлаас гүний усанд бохирдол үүсэх магадлалтай. Энэ нөлөөлөл нь хүний үйл ажиллагаанаас шууд хамаараалтай.

Ашиглалтын явцад гарч болох төмөр замын аливаа аваар, осол нь түлш шатахуун, химийн бодис зэргийн асгарах шалтгаан болж улмаар энэ нь дангаар болон борооны устай холилдон хөрсөнд нэвчин гүний усыг бохирдох сөрөг нөлөө учирч болзошгүй.

Газрын гүнээс усыг хяналтгүйгээр авч ашиглах, бохирдсон усыг ил задгай гадаргууд замбараагүй асгах нь гүний усны чанарт сөргөөр нөлөөлнө.

3.4. Хөрсөн бүрхэвч

Зам барилгын ажлын үед хайрга, шороо зөөж тээвэрлэх явцад хүнд даацын машинууд олон салаа зам үүсгэвэл тухайн орчмын хөрс, ургамлан бүрхэвчийг сүйтгэж, техноген элэгдэл эвдрэлд оруулж болзошгүй.

Бензин, шатах тослох тос, тосолгооны материал, дизелийн шүүрэлт гарах мөн ариун цэвэр, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүснэ.

Машин техникийн дутуу шатаасан утаагаар агаар орчныг бохирдуулдгаас гадна 1 л дизель түлш шатахад 0.4 гр хар тугалга ялгаруулах бөгөөд шатсаны дараа 0.75% нь агаарт, үлдсэн хувь нь газрын гадаргууд шингэдэг.

3.5. Ургамлан нөмрөг

Замын ажлыг хийж гүйцэтгэх үед машин техник хүний үйл ажиллагаагаар нийт 1,960.3 га газрын ургамлан бүрхэвч талхлагдаж, зүйлийн бүрдлийн унаган төрх алдагдах, тоосны нөлөөгөөр ургамлан бүрхэвч доройтох зэрэг нөлөөлөл үүсэх;

Зам тавихад ашиглагдах машин техникээс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50 м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах сөрөг нөлөөтэй. Энэ нь хуурай, халуун, хэт гандуу цөлийн эмзэг хөрсөнд ургаж байгаа ургамлуудын хувьд өвчин, ганд тэсвэрлэх чадамж нь буурч тухайн орчны ургамлан нөмрөг сийрэгших, төрөл зүйлийн тоо цөөрөх нөлөөллийг үзүүлж болзошгүй;

Зам ангийн түр тосгон бий болсноор тухайн орчимд хүн, машин техник их холхиж, тосгоны ойр орчмын ургамлан нөмрөг ихээр талхлагдана;

Төмөр замын трассын дагууд ховор ургамал болох *Oxytropis aciphylla* (Өргөст ортууз) шууд нөлөөлөлд өртөнө;

Замд ашиглагдах хайрга, элс шорооны овоолго, түр зуурын хуримтлал үүсгэсэн тохиолдолд тухайн орчны ургамлан нөмрөг дарагдаж талхлагдана.

3.6. Амьтны аймаг

Төслийн талбай нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалын хувьд Монгол-Төвдийн их муж, Монголын ойт хээрийн дэд муж, дорнод говийн тойрогт хамрагдана. Төслийн талбай орчимд 8 багийн 43 зүйл хөхтөн амьтан, 11 багийн 83 зүйл шувуу, 5 зүйлийн гүрвэл, 4 зүйлийн могой, 1 зүйлийн хоёр нутагтан тархсан.

Төслийн талбай орчим нь Монгол орны говь, цөлийн бүсийн түлхүүр зүйл амьтад болох хулан, хар сүүлт зээр, цагаан зээр болон аргаль, янгир зэрэг ховор, устах эрсдэлтэй, хамгааллын статус өндөртэй зэрлэг амьтад түгээмэл тархсан хүний үйл ажиллагааны нөлөөлөлд харьцангуй бага өртсөн амьдрах орчин юм.

Шинээр тавигдах төмөр замын төслийн бүтээн байгуулалт болон ашиглалтын үед үүсэх сөрөг нөлөөлөл тал хээр, говь цөлийн бүсийн зэрлэг амьтад үзүүлэх сөрөг нөлөөлөл өндөр байгаа тул зэрлэг амьтад зориулсан төмөр замын гарц, гармуудыг стандартын дагуу төлөвлөх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг жил бүр тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.

Төмөр замын нүхэн, гүүрэн болон нэг түвшний гарам бүхий хэсгүүдэд хөдөлгөөн мэдрэгч камер байршуулан нүүдлийн зэрлэг хөхтөн амьтад дээрх гарцуудыг хэрхэн ашиглаж буй талаар судалгаа хийж, гарцуудын ашиглалтыг сайжруулах ажлуудыг тогтмол зохион байгуулах шаардлагатай. Ялангуяа нэгэнт баригдсан төмөр зам, авто зэрэг байгууламжуудад нэмж байгуулах боломжтой нэг түвшний гармуудын ашиглалтыг судалж, байршлыг өөрчлөх, шинээр байгуулах, өргөсгөх зэрэг арга хэмжээ авах боломжтой.

3.7.Тусгай хамгаалалттай газар

Төмөр замын трасс нь Улсын тусгай хамгаалалтад авсан Говийн бага дархан цаазат газрын "Б" хэсгийн орчны бүстэй, Орон нутгийн тусгай хамгаалалттай Толийн булаг, Өөшийн говь, Бор нуруу, шар заагийн хоолой гэсэн 3 газартай давхцалтай байна.

3.8. Түүх, соёлын биет өв

Археологи

Тус хайгуул судалгааны дүнд түүх, соёлын үл хөдлөх 11 дурсгал илрүүлэн бүртгэсэн ба Хүрэл зэвсгийн үед холбогдох булш 4, Монгол гүрний үед холбогдох булш 5, он цаг тодорхойгүй 2 дурсгал нь археологийн үнэт хэрэглэгдэхүүн илэрсэн тул эдгээр дурсгалын хадгалалтад анхааран Монгол улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 7-р зүйл, Газрын тухай хуулийн 5-р бүлгийн 31.4, 34.11 болон 40.1.4-р зүйлд тус тус заасныг үндэслэл болгон төмөр замын ажилд өртөх тохиолдолд малтан судалж, тухайн талбайгаас чөлөөлөх шаардлагатай.

Палеонтологи

Төмөр замын зурвасын /10 км радиус/ дагуу талбайд гүйцэтгэсэн палеонтологийн газрын гадаргын хайгуул судалгаагаар эртний амьтан, ургамлын макро түвшний үлдвэр илрээгүй. Гэвч судалгааны талбайн дийлэнх хэсгийг палеонтологийн үлдвэр агуулах боломжтой чулуулаг бүрдүүлж байгаа тул онцгой анхааралтай ажиллах хэрэгтэй. Газар шорооны ажлын үед эртний нугаламт болон нугаламгүй амьтдын үлдвэр илрэх өндөр

магадлалтай ба илэрсэн даруйд Палеонтологийн хүрээлэнд мэдэгдэн авран хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай. Мөн палеонтологийн нөлөөлөл өндөр болон албан дүгнэлтэд онцгойлон нэр дурдагдсан талбайд ажил эхлэхийн өмнө сургалт авах шаардлагатай.

3.9. Нийгэм, эдийн засаг

Орон нутгийн ажил эрхлэлт, мэргэжил боловсрол, дэд бүтцийн хөгжил нэмэгдэж, ард иргэдийн аж амьдрал сайжирна. Гэхдээ орон нутгийн иргэдийн мэргэжил, боловсрол түвшин төслийн шаардлагад хүрэхгүй, ажилд орж чадаагүйн улмаас төслөөс ахиц өөрчлөлт хүлээж байсан иргэд сэтгэл дундуур үлдэх, гомдол, эсэргүүцэл гарч болзошгүй.

- Төслийн талбай, түүний ойр суурьших айл өрхийн амьдралын хэвийн байдал өөрчлөгдөнө.
- Төсөл хэрэгжсэнээр хүний хөл олширч, гэмт хэрэг, танхайн хэрэг, осол аваар нэмэгдэж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас бэлчээрийн талбай багасаж, бэлчээрийн хомсдол үүсэж, хүн малын ус хангамжид ашигладаг худгийн усны түвшин буурч болзошгүй.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Ханги-Мандал чиглэлийн төмөр зам барих төслийн БОМТ-ний гол зорилтуудыг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд тухайлбал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2017 оны 5 дугаар сард УИХ баталсан Хог хаягдлын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн баталж гаргасан журам, стандарт, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн тус төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам” зэрэгт үндэслэн тодорхойлов.

Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618 журмын 2.15 дахь заалт). Дэд бүтцийн төслийн бүтээн байгуулалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгана (А/618 журмын 2.17 дахь заалт).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана (БОНБУ-ний тухай хуулийн 9.9 дахь заалт).

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрдэнэ.

Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
8. Тухайн жилийн байгаль менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Энэхүү бүтээн байгуулалтын төслийн 2026 онд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардал урьдчилсан байдлаар 56'195'200 төгрөг (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д/д	Авах арга хэмжээний нэр	Зардал, төгрөг
		2026 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7'450'000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн Төлөвлөгөө	38'290'200
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10'455'000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт		56'195'200

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян. төг/	Нэгжийн болон нийт зардал /мян. төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт, аргачлал
Агаарын чанар						-	
Газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг услах, чийглэх (Хуурайшилттай үед)	Зам талбай	Рейс	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгав		Агаарын тухай хууль, 9, 11, 23-р зүйл MNS 4585:2016
Халаалтын зуух, ажилчдын амрах байрны галлагаа болон машин, техникийн түлшний дутуу шаталтаас бохирдуулагч хий ялгарах	Дизель хөдөлгүүртэй техникт утааны шүүлтүүр суурилуулах	Талбайд ажиллаж буй техник хэрэгсэл	ш	Техник бүрт	Үйл ажиллагааны зардалд тусгав		Зөрчлийн тухай хууль 6.24 заалт
Ахуйн хог хаягдал шатааж агаар бохирдуулах	Хог хаягдал хадгалах түр цэгт хуримтлагдсан хаягдлыг сумын төвийн нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөх, зөвшөөрөл авах	Төсөл хэрэгжүүлэгч, Туслан гүйцэтгэгч компанийн кемп	Удаа	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав			Зөрчлийн тухай хууль 6.1 заалт
Гадаргын усны түр урсац, үерийн сувгууд шатах тослох материалын асгаралтаас бохирдох	Тослох, шатах материалыг хадгалах, тээвэрлэх, ашиглах аюулгүй ажиллагааны журам боловсруулж хэрэгжүүлэх	Хуурай сайрын ойролцоо	-				Байгаль орчныг хамгаалах, Усан мандал, Гадаргын усны чанарыг хянах журам MNS 4047: 1988, Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586-1998.
	Асгаралтын эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх						

Үер усны эрсдэл	Замын ашиглалтын явцад ус нэвтрүүлэх хоолойнууд хагшаас, хурдсаар дүүрэх магадлалтай тул үер болж өнгөрсний дараа цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэх	Төмөр замын трасс дагуу барих 4 гүүр, 234 төмөр бетон хоолой	ш	238	Үйл ажиллагааны зардалд тусгав		Төмөр замын тээврийн тухай хууль
Газрын доорх ус						3'450.0	
Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын үеийн далангийн усалгаанд зориулан 24 ш, Төмөр замын өртөө, зөрлөгийн ажиллагсдын унд ахуйн хэрэглээнд 12 ш гүн өрмийн худаг гаргаж ашиглах учир тухайн орчны газрын доорх усны түвшин буурах	Усны тоолуур суурилуулах	Төмөр замын трасс дагуух болон өртөө, зөрлөгт гаргасан худаг	ш	6	500.0	3'000.0	БОНХЯ-ны Сайдын 2013 оны А-156 тоот тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
	Тоолуурын баталгаажуулалт хийлгэх	Төмөр замын трасс дагуух болон өртөө, зөрлөгт гаргах худаг	ш	6	75.0	450.0	
	Худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох	Өртөө, зөрлөгт гаргасан худаг	ш	6	-		Усны тухай хууль
	Усыг ариг гамтай ашиглах талаар сургалт сурталчилгааг туслан гүйцэтгэх компани болон ажилчдад хийх	Төсөл хэрэгжүүлэгч, туслан гүйцэтгэгч компаниуд	-	-	-		Усны тухай хууль
	Усны боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглах дүгнэлтэд заасан хэмжээнээс давуулалгүй усыг ашиглах	Бодлогын түвшинд					
	Худгийн усны түвшний хэмжилт хийх	Кемп болон төмөр замын ажиллагсдын ашиглах	ш	4	ОХШХ-ний зардалд тусгав		MNS 3342 : 1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага, MNS 4943:2015

							Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий Шаардлага, MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
Хөрсөн бүрхэвч							-	
Олон салаа зам бий болгож газрын гадаргын өнгөн хэсгийг талхлах	Олон салаа зам үүсгэхгүй байх, маршрутын дагуу түр замаар зорчих, газар шорооны ажлын дараа шороон асгаас, овоолгуудыг газрын гадаргын төрх байдалтай уялдуулан тэгшлэх	Төсөл хэрэгжүүлэгч, туслан гүйцэтгэгч компаниуд	га	-			Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	
Ургамлан нөмрөг							-	
Трасс дагуух заган ой устгах	Ижил төстэй орчинд залуу загийг шилжүүлэн суулгах эсвэл төмөр замын өртөө, зөрлөгүүдэд ногоон байгууламж бий болгох	Төмөр замын трассын 44 дэх км буюу 1-р зөрлөгийн ойролцоо	ш	5000	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгав		Ойн тухай хууль, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	
Бүтээн байгуулалтын ажлын үед ургамлан нөмрөг устгах	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах	Төсөл хэрэгжүүлэгч	Үйл ажиллагааны зардалд тусгах					
Амьтны аймаг							4'000.0	
Төмөр замын бүтээн байгуулалт, ашиглалтын үед үүсэх машин	Монгол улсын улаан ном, бүс нутгийн болон олон улсын улаан данс (IUCN), бусад хууль тогтоомж,	Үндсэн болон гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллагын ажилчид	Удаа	1	4'000.0	4'000.0	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчны	

механизмын дуу чимээ, тоосжилт зэрэг хүний үйл ажиллагаанаас болж зэрлэг амьтад дайжих	гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалт зохион байгуулах						нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
Нүүдлийн хөхтөн амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, амьдрах орчны тасархайтал үүсгэх	Сансрын дамжуулагч хүзүүвч суурилуулах замаар хулан, хар сүүлт, аргаль зэрэг нүүдлийн зэрлэг амьтдын төмөр замын нүхэн гарц, гүүрэн гарц болон давуулах далан ашиглах хугацаа, байршил, ашиглалтын эрчмийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд ашиглалтын эрчмийг сайжруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх	Төмөр замын трассын 1.9, 30.0, 39.8, 48.9, 49.9, 59.7, 66.6, 80.4, 100.8, 121.9, 132.3, 158.4, 173.4, 186.1, 217.2 км	ш	Байгаль хамгаалах олон улсын байгууллагуудтай хамтарна.			
	Нэг түвшний газар буюу гармын тоог нэмэгдүүлэх	Төмөр замын трасс дагууд	км	226.9	Үйл ажиллагааны зардалд тусгах		
	Хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулах замаар хулан, хар сүүлт, аргаль зэрэг нүүдлийн зэрлэг амьтдын төмөр замын нүхэн гарц, гүүрэн гарц болон давуулах далан ашиглах хугацаа, байршил, ашиглалтын эрчмийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд ашиглалтын эрчмийг сайжруулах арга	Хулан - 10, Хар сүүлт - 10 Аргаль - 3	ш	Байгаль хамгаалах олон улсын байгууллагуудтай хамтарна.			

	хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх					
	Мэргэжлийн байгууллагаар амьтны судалгаа хийлгэх, дүгнэлт гаргуулах	Төмөр замын трасс дагууд болон төмөр замаас 2 тийш 20 км зайд	Удаа		Байгаль хамгаалах олон улсын байгууллагуудтай хамтарна.	
Хууль бус ан, агнуурын улмаас зэрлэг амьтдын тоо, толгой цөөрөх, устах	Хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай журмыг хэрэгжүүлэх	Үндсэн болон гэрээт, туслан гүйцэтгэгч байгууллагын ажилчид			-	
Орон нутгийн малчин иргэдийн амьдрах орчин					-	
Төмөр зам тавьснаар бэлчээрийн талбай хумигдах, хуваагдах	Малчид нүхэн гарц, гүүр хоолойгоор малаа хариулж бэлчээрийн талбайг сэлгэн ашиглаж сурах, дадах ажлыг зохион байгуулах, сургалт явуулах	Төмөр зам дагуух айл өрхүүдэд	ш	40	Зардал шаардахгүй	Дотоод зохион байгуулалтаар
	Мал, амьтны гарц гарам дээр тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Төмөр замын трассын дагууд	км	226.9	Үйл ажиллагааны зардалд тусгах	Төмөр замын тээврийн тухай хууль
Нийт дүн					7'450.00	

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, /мян.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Биологийн нөхөн сэргээлт						38'290.2	
Төмөр замын трассын нөлөөнд өртөж буй залуу заг модыг ижил төстэй орчинд тарих	Нүх ухах, тээвэрлэх, суулгах, арчилгаа тордлогоо хийх	Ойролцоогоор 21950 ш мод устсан тул уг мод байсан талбайг ургамалжуулж, ойжуулах	ш	7000	5470	38'290.2	• Заг тарьж ургуулах гарын авлага, 2010 он • Сухай тарьж ургуулах гарын авлага, 2010 он • Хайлаас тарьж ургуулах гарын авлага, 2010 он • Жигд тарьж ургуулах гарын авлага, 2010 он
Нийт						38'290.2	

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Археологи: “Монголиантранс лайн” ХХК нь Улаанбаатар их сургуулийн Археологийн хайгуул судалгааны багаар “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын төслийн 226 км замын трасс дагуу 2022.04.01-07-ны өдрүүдэд археологийн хайгуул судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Археологийн хайгуул судалгааны ажлыг төмөр замын трассаас 2 тийш 100 метр өргөнтэй хайгуулын талбай үүсгэн, тухайн газар орны байдлаас шалтгаалан дурсгал байж болох хэсгүүдэд илүү өргөн хүрээтэй самнах байдлаар хийсэн байна. Трассын 120-121 дах цэгийн хооронд түүх, соёлын үл хөдлөх дурсгал замын трассын зүүн талд замаас 400 гаруй метр зайд хоорондоо ойролцоо 4 дурсгал, дээрх дурсгалуудаас урагш 500 орчим метр зайд замын трассын баруун талд замаас 20-100 метрт 5 дурсгал илрүүлсэн ба энэ газрыг нутгийнхан Шивнээн булаг хэмээн нэрлэдэг. Трассын 150 дах цэгийн орчимд Шархад хэмээх газар хайгуул хийх явцад замын баруун талд 120-200 гаруй метрт 2 дурсгал бүртгэгдсэн. Тус хайгуул судалгааны дүнд түүх, соёлын үл хөдлөх 11 дурсгал илрүүлэн бүртгэсэн ба Хүрэл зэвсгийн үед холбогдох булш 4, Монгол гүрний үед холбогдох булш 5, он цаг тодорхойгүй 2 дурсгал нь археологийн үнэт хэрэглэгдэхүүн тул эдгээр дурсгалын хадгалалтад анхааран Монгол улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 7-р зүйл, Газрын тухай хуулийн 5-р бүлгийн 31.4, 34.11 болон 40.1.4-р зүйлд тус тус заасныг үндэслэл болгон төмөр замын ажилд өртөх тохиолдолд малтан судалж, тухайн талбайгаас чөлөөлөх шаардлагатай гэж дүгнэсэн.

Палеонтологи: ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаар хайгуул судалгааны ажлыг 2022 оны 4-р сард хийж гүйцэтгүүлсэн. Судалгааны талбайн 75% нь мезозойн цаг үеийн тунамал хурдаснаас бүрдсэн. Төмөр замын зурвасын /10 км радиус/ дагуу талбайд гүйцэтгэсэн палеонтологийн газрын гадаргын хайгуул судалгаагаар эртний амьтан, ургамлын макро түвшний үлдвэр илрээгүй. Гэвч судалгааны талбайн дийлэнх хэсгийг палеонтологийн үлдвэр агуулах боломжтой чулуулаг бүрдүүлж байгаа тул онцгой анхааралтай ажиллах хэрэгтэй. Газар шорооны ажлын үед эртний нугаламт болон нугаламгүй амьтдын үлдвэр илрэх өндөр магадлалтай ба илэрсэн даруйд Палеонтологийн хүрээлэнд мэдэгдэн авран хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай. Мөн палеонтологийн нөлөөлөл өндөр болон албан дүгнэлтэд онцгойлон нэр дурдагдсан талбайд ажил эхлэхийн өмнө сургалт авахыг зөвлөсөн.

БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал	Баримтлах стандарт, аргачлал
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Үйл ажиллагааны зардалд тусгах		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх			
Нефтийн бүтээгдэхүүнтэй байнга харьцаж ажилладаг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Нефтийн бүтээгдэхүүний физик, химийн шинж чанар, тэдгээртэй ажиллах, хадгалах, тээвэрлэх үед мөрдөх аюулгүй ажиллагааны зохих мэдлэгийг эзэмшүүлэх	Зардал шаардахгүй, өдөр тутмын ажлын наряд дээр зааварчилгаа өгөх боломжтой.		Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
Шатах тослох материалаар хөрс бохирдох	Засварын цэг, машины зогсоол орчимд асгаралтын иж бүрдэл, элс, үртэс зэргийг байршуулах, асгаралтыг нэвчих, тархахаас сэргийлэх, бохирдсон хөрсийг төмөр поошгинд цуглуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах		Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ MNS 5850:2019
Шатахуун хадгалах нөөцийн сав /ёмкость/ цоорох, түлш цэнэглэх явцад гоожих, асгарах зэргээр хөрсний бохирдол үүсгэх	Ёмкостны бүрэн бүтэн байдлыг тухай бүр шалгах, пелонк дэвсэж хөрсөөр хучсаны дараа саваа байрлуулах, жижиг хэмжээний асгаралт гоожилт болбол тэр даруй хусаж авч цэвэрлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах		Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ MNS 5850:2019
Химийн бодис, бүтээгдэхүүний хаягдлын тоосжилт, ууршилт бүхий хэсгүүд салхиар дамжин хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Төслийн талбайн эргэн тойронд мод тарих, ойжуулах, ургамалжуулах зэргээр тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны зардалд тусгах		Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 0017-2-3-16:1998 (Суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

Задгай талбайд болон агуулахад хадгалагдаж буй шингэн түлш (бензин, дизель түлш) уур, тэдгээрийг шингээсэн тоос салхиар дамжин агаарт дэгдэх	Бодис, бүтээгдэхүүн байршуулсан задгай талбайн эргэн тойрныг мөн ургамалжуулж чийгтэй байлгах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 0017-2-3-16:1998 (Суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага
Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах ууршилттай, дэгдэмхий химийн бүтээгдэхүүн агаарт уурших, исэлдэх урвалд орох, салхиар тарах зэргээр агаарын чанар, найрлагыг өөрчлөх, хаягдлыг шатаах аргаар устгах үед хортой хий ялгаран агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Сав баглаа боодлыг сайтар шалгаж, нар, салхинд элэгдэх элэгдлийг тооцох	Үйл ажиллагааны зардалд тусгах	Агаарын тухай хууль /2012.05.17/ зүйл 13-2, зүйл 19, зүйл 20-1, 2,3,4,6. Байгаль орчныг хамгаалах тухай хууль/ 2012.05.17/, Монгол улсын стандартууд, MNS /ISO/4226:2000 “Агаарын чанар”, MNS 4585:1998, “Агаар орчны чанарын үзүүлэлт”
Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт нөлөөлөх	Химийн бүтээгдэхүүн, бодисыг ашиглах, хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, хадгалах, ашиглах болон тээвэрлэх үед савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Галын аюулгүй байдлын тухай хууль /2012.05.17/ “Гамшгаас хамгаалах тухай” хууль, Химийн хорт бодисын тухай хууль

Төмөр замын бүтээн байгуулалтад ашиглагдах бензин, шатахуун нь онцгой шатамхай шингэнүүд тул гал түймэр гарах, тэсрэх дэлбэрэх аюултай ба их хэмжээтэй ашиглагдах нь онцгой эрсдэлтэй. Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр аюултай химийн бодис тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах	Үйл ажиллагааны зардалд тусгах	“Гамшгаас хамгаалах тухай” хууль “Галын аюулгүй байдлын тухай” хууль “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль 2006.05.25. БНБД 21-01-02 Барилгын гал тэсвэрлэлтийн зэрэг
	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах		
	Тэсэрч дэлбэрэх, галын аюултай бодисуудыг нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах, хамгаалалтын хатуу дэглэм тогтоох		
	Хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх, Ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд хадгалах, Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах		
Гэмтэл гарах тохиолдолд галын аюул гарч шатамхай, ууршимтгай, тэсрэмтгий шинж чанартай химийн бүтээгдэхүүн, бодисоос осол аюул үүсэх	Барилга байгууламжийн доторх цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийг галын онц аюултай байгууламжид шаардагдах стандартын дагуу хийж, тогтмол үзлэг шалгалт хийж байх, Галын аюулаас хамгаалах болон ил гал гаргахыг хориглосон бүс тогтоож, анхааруулга санамж, зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг хийх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс төслийн үйл ажиллагаа доголдох, тээвэр зогсох	Цаг агаарын 7 хоногийн, өдөр тутмын урьдчилан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт		-	

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн хог хаягдал	Хогийн цэгүүдийг хашаажуулж, тохижуулах	Өртөө, зөрлөгүүд	Ш	5	Үйл ажиллагааны зардалд туссан		Хог хаягдлын тухай хууль
	Сумдтай хог хаягдлын гэрээ байгуулах	Өртөө, зөрлөгүүд	Удаа	3	Үйл ажиллагааны зардалд туссан		Хог хаягдлын тухай хууль
	Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялгаж хоёрдогч түүхий эд авах цэгүүдэд тушаах	Өртөө, зөрлөг болон туслан гүйцэтгэгч компаниудын кемп	Рейс	Тухай бүр	Үйл ажиллагааны зардалд туссан		Хог хаягдлын тухай хууль
	Төмөр замын ашиглалтын үед салхинд хийсэж ирсэн хатуу хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Төмөр зам дагуу болон үерийн ус өнгөрөөх, зайлуулах шугам хоолой	Рейс	Тухай бүр	Үйл ажиллагааны зардал		Хог хаягдлын тухай хууль
	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг хөрсөнд асгаж бэлчээрийг доройтуулахгүй байх, септик систем ашиглах	Зөрлөг болон туслан гүйцэтгэгч компаниудын кемп	ш	Төсөл хэрэгжүүлэгч, туслан гүйцэтгэгч	Үйл ажиллагааны зардалд туссан		Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
	Нүхэн жорлон байгуулснаар хөрсний бохирдол үүсгэх учир стандартад нийцсэн жорлон байгуулж, газар шорооны ажлын дараа халдваргүйжүүлэх, хүн мал унахаас сэргийлж булах	Туслан гүйцэтгэгч компаниудын кемп	ш	Компани тус бүр	Үйл ажиллагааны зардалд туссан		Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015

	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг ил задгай асгахгүй байх	Төмөр замын өртөө, зөрлөг, кемп	ш	-	Үйл ажиллагааны зардал болон туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагааны зардалд туссан	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
Аюултай хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдал, техник хэрэгслээс ашигласан тос, тосолгооны материал болон түүний баглаа боодол, эвдэрсэн, хуучирсан сэлбэг хэрэгсэл гарах ба тусгай цэгт төвлөрүүлж тусгай зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх	Төсөл хэрэгжүүлэгч	ш	-	Үйл ажиллагааны зардалд туссан	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
Нийт зардал					-	

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР						
Хүхрийн исэл SO ₂ , Азотын давхар исэл NO ₂ , Нүүрстөрөгчийн дутуу исэл CO ₂ Тоос PM ₁₀ Дуу чимээ	Өртөө, зөрлөг	9 дүгээр сарын 15-20-ны дотор 12 цэгт, нийт 24 дээж	18	1 дээжийн үнэ 47.5	1140.0	Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82, Агаарын чанар MNS 4585:2016
	Төмөр замын трассын дагууд	/4 эсвэл 9 дүгээр сарын 15-20-ны дотор/ 16-н цэгт	16	1 дээжийн үнэ 47.5	760.0	
Дүн					1'900.0	
2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС						
Усны химийн найрлага, хүнд металлын агууламж, бактериологи, органик бохирдол, усны түвшний хэмжилт хийх	Төмөр замын ашиглалтын үед өртөө, зөрлөгт ашиглах 7 худаг	Жилд 4 удаа /3, 6, 9, 12 дугаар сарын 15-20-ны дотор/, 13 цэгээс Нийт 52 дээж	52	1 дээжийн үнэ 100.0	5'200.0	Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0900:2018, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий Шаардлага MNS 4943:2015, Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010
	2 өртөө дээрх цэвэрлэх байгууламж	Жилд 4 удаа /4, 9 дүгээр сарын 15-20-ны дотор/ 4 цэгээс Нийт 16 дээж	8	1 дээжийн үнэ 55.0	880.0	
Дүн					6'080.0	

3. ХӨРС, ГАЗРЫН ГАДАРГА						
Агрохимийн үзүүлэлтүүд (ялзмаг, рН, $EC_{2.5}$ dS/m, P_2O_5 , K_2O , $CaCO_3$, NH_4 , NO_2 , NO_3), Механик бүрэлдэхүүн (тоос, элс, шавар)	Төмөр замын трасс дагуу, түр зам дагуу, ажилчдын кемп орчим, өртөө, зөрлөг, карьер, ногоон байгууламж болон мониторингийн цэгүүд	Жилд 1 удаа 30 цэг (9 дүгээр сарын 15-20-ны дотор)	30	1 дээжийн үнэ 35.0	1'050.0	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1991, Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305:1994, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга MNS 3310:1991, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019
Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Co гэх мэт)	Машин техникийн зогсоол, төмөр замын трасс дагуу, түр зам дагуу, карьер, ажилчдын кемп орчим, өртөө, зөрлөг болон мониторингийн цэгүүд	Жилд 1 удаа 25 цэг (9 дүгээр сарын 15-20-ны дотор)	25	1 дээжийн үнэ 33.0	825.0	
Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт (нянгийн тоо, гэдэсний бүлгийн савханцрын колититр, Перфрингенсийн таньц (Анаэроб))	Кемпийн хог хаягдал түр хадгалах цэг, нүхэн жорлон, өртөө, зөрлөг	Жилд 1 удаа 20 цэгт (9 дүгээр сарын 15-20-ны дотор)	20	1 дээжийн үнэ 30.0	600.0	
Дүн					2'475.0	
Нийт дүн					10'455.0	

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төмөр замын ашиглалтын явцад үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ. Зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг дор тусгав. (Хүснэгт 8)

Хүснэгт 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Авах арга хэмжээ		Төсөв, мян.төг	Хугацаа, давтамж	Хариуцагч
1	Байгаль орчны менежмент төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Төсөл хэрэгжүүлэгч
2	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвлөн, санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх, 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлэх	Тухайн жилийн БОМТ-нд тусгагдсан зардал	Жил бүр	Төсөл хэрэгжүүлэгч
3	Ус ашиглах зөвшөөрөл авах, дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Төсөл хэрэгжүүлэгч
4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх (газар шорооны ажлын үед болон дараа нь туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанд)	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Төсөл хэрэгжүүлэгч

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Монголиантранс лайн” ХХК нь ““Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл”-ийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Дорноговь аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх ба бүх шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. (Хүснэгт 9).

Хүснэгт 8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
“Монголиантранс лайн” ХХК-ийн удирдлага		Уулзалт, тайлагнах	БОМТ-нд тусгагдсан ажлууд, түүний хэрэгжилтийн талаар	Улирал бүр	Хэрэгжилтийн үйл явцыг дотооддоо хэлэлцэх	Төв оффис
Орон нутаг	Багийн ИНХ	Хуралд танилцуулах, хэлэлцүүлэх	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт, ирэх онд хийхээр төлөвлөсөн БОМТ-д тусгагдсан арга хэмжээ	Жил бүрийн 11-12 сар	Ирэх оны төлөвлөгөөний төсөл дээр санал авах	Багийн төв
	Сумын ЗД, БОХУБайцаагч, газрын даамал	Уулзалт				Сумын төв
Төрийн захиргааны төв байгууллага болон аймгийн Байгаль орчны алба	БОУАӨЯ-ны ХБОБХГ, Аймгийн Байгаль орчны газар	ТЖБОМТ-г хянуулах			Хянуулах, батлуулах	УБ хот, БОУАӨЯ Дорноговь аймгийн БОГ